

“ЭХ” БА “ЭЦЭГ” ЭСЭЭГ ЗОХИОГЧИЙН УРАН
ЧАДВАРЫН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Т.Баасансүрэн*

* МОНЦАМЭ агентлагийн захирал, түүхийн ухааны доктор (Ph.D.), шүүмжлэгч

Түлхүүр үг: үргэлжилсэн үгийн зохиол, бичлэгийн төрөл, зүйл, эсээ, баримт, дүр.

Монголын утга зохиолын нэрд гарсан судлаач шүүмжлэгч, үргэлжилсэн үгийн авьяаслаг зохиолч Бажуудайн Ганбат нь зөвхөн зохиолч, шүүмжлэгч, судлагч төдийгүй, олон олон сэтгүүлч, идэвхтэн бичигчийг өөрийн бүтээл туурвилаараа үлгэрлэн дагуулсан нэртэй сайн нийтлэлч, сэтгүүлч байв. Тэрбээр Улаанбаатар хотноо УБДС-ийг монгол хэл-уран зохиолын багшийн мэргэжлээр төгсч, сүүлд Москва хотноо А.М.Горькийн нэрэмжит Утга зохиолын дээд сургуулийн дэргэдэх дээд курст тус тус суралцаж төгссөн боловч “Үнэн” сонины газар, Монголын сэтгүүлчдийн холбоо, УИХ-ын Хэвлэл, мэдээллийн албанд нийтдээ 31 жил ажилласан байна. Өөрөөр хэлбэл өөрийнх нь нэгэнтээ дурсан бичсэнээр “Үнэн” сонин хэмээх Академид 18 жил, Монголын сэтгүүлчдийн армийн төв штабт 3 жил, ерэн оны ардчилал шинэчлэлийн үр дүнд Монголд

бүрэлдэн төлөвшсөн байнгын үйл ажиллагаатай парламент — УИХ-ын Хэвлэл мэдээллийн алба буюу бүр тодруулбал “Төрийн мэдээлэл” ба “Төр, засгийн ажилтанд тусламж” сэтгүүлд 10 жил ажиллажээ. Улс, нийгэмд биеийн хүчин үнэлж хөдөлмөрлөсөн энэ гурван арван жилд тэрбээр олон зуун нийтлэл, мэдээ мэдээлэл, ярилцлага, сурвалжлага, хөрөг, найруулал, эсээ, тэмдэглэл, дуртгал бичиж төвийн сонин, хэвлэлүүдэд нийтлүүлсэн байна.

Заримаас нь иш татаж нэрлэбэл “Асуултын гурван тэмдэг буюу бидний толгой доторх хярамцаг”, “Бидний араншин хэмээх зургаан таталбар”, “Бурхан ээж”, “Дэлгэц аллага, садар самуунд эзлэгдэх нь”, “Лодойдамба хэмээх заан мод”, “Луу, баавгай хоёр хаашаа, би тийшээ”, “Мартагдсан үлгэр”, “Монголчууд материалист маягийн сэтгэлгээтэй”, “Сонгууль, мөнгө хоёр”, “Сэтгүүлчид хэний “өмч” вэ?”, “Төр засалцах хүнд байж болшгүй чанар бол урвагч шинж”, “Түүх болбоос үлгэр домог биш, түүнийг мартаж болохгүй”, “Хазахаас бусад мэх буюу сонгуулийн

үеийн бохир арга", "Хятадууд Мао Зэдунд хайртай юу?" гэх зэргээр нийтлэлүүдийг нь нэрлэн цааш үргэлжлүүлж болно. Гарчгийг нь харж, нэрийг нь сонсоод утга агуулга нь та бүгдийн заримынх нь сэтгэл оюунд урган сэргэж ч байж магадгүй. Хүний нүд бол сэтгэлийнх нь толь, сонины гарчиг — агуулгынх нь толь гэж би сэтгүүл зүйн ангийн оюутнуудад үе үе сануулж хэлдэг юм. Бажуудайн Ганбатын дээрх нийтлэлүүдийн гарчгаас утга агуулга нь илэрхий мэдрэгдэж байна. Энэ бол сэтгүүлч Б.Ганбатын нийтлэлүүдийнх нь нэг гол онцлог юм гэдгийг тэмдэглэж хэлье.

Бажуудайн Ганбат бол Монголын сэтгүүл зүйд өөрийн тод гэгээн мөрийг үлдээсэн авьяаслаг нийтлэлч байсан гэдэгтэй өнөөдөр хэн ч маргахгүй бизээ. Энэхүү дүгнэлтээ би түүний хоёрхон эсээгээр жишээлж батлах оролдлого хийе. Сэтгүүлч, нийтлэлч Бажуудайн Ганбат "Үнэн" сонины 1989 оны 3-р сарын 8-ны өдрийн №57 (17274)-д өөрийн бичсэн алдарт "Эх" хэмээх эсээг нийтлүүлжээ. "Эх" эсээ нь "Эхийн сүү", "Эхийн бүүвэй", "Эхийн хайр", "Эхийн ач", "Эхийн эрдэм", "Эхийн сэтгэл", "Эхийн зориг", "Эхийн нүд", "Эхийн совин", "Эхийн сүр" гэсэн үндсэн 10 хэсгээс бүрдэж байна. Зохиогч "Эх" эсээгээ бичиж туурвихын тулд ихээхэн бүтээлч эрэл хайгуул хийж, эх

хүний эрхэм нандин чанарыг илэрхийлэн гаргаж чадах эрдэнийн арван шигтгээг олж цуглуулж, түүнийгээ нэгтгэж нийлүүлэн сүлжилдүүлж урлажээ. Энэ нь үлгэр домог, үнэн бодит баримт, утга зохиолын дээжис бичгийн ишлэл, өөрт тохиолдсон амьдралын мартагдашгүй содон агшин зэрэг болно.

Монголын үзэсгэлэнт саран гуа
намайг төрүүлсэн
ижий

«

*Гарчгийг нь харж, нэрийг нь сонсоод
утга агуулга нь та бүгдийн
заримынх нь сэтгэл оюунд урган
сэргэж ч байж магадгүй. Хүний нүд
бол сэтгэлийнх нь толь, сонины
гарчиг — агуулгынх нь толь гэж би
сэтгүүл зүйн ангийн оюутнуудад үе
үе сануулж хэлдэг юм. Бажуудайн
Ганбатын дээрх нийтлэлүүдийн
гарчгаас утга агуулга нь илэрхий
мэдрэгдэж байна.*

»

Яруу сайхан
эгшгээрээ бөн бөн
бүүвэйлсэн ижий

Зөөлөн цагаан
гараараа хөдөлгөн
өсгөсөн ижий

Зүйтэй уран
үгсээрээ сурган
хүмүүжүүлсэн ижий
хэмээх их зохиолч
Дашдоржийн На-
цагдоржийн эрдэ-
нийн дөрвөн мө-
рийг эсээнйхээ

магнайд шигтгэж залсан нь ч нэгийг хэлж байгаа бололтой. Ямар ч байсан "Эх" хэмээх эсээг зохиогч хичээнгүйлэн бодож бясалгаж, ихээхэн цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулан байж бичиж, түүнийгээ гойд гоёмсгоор зохиож зохиомжилсон нь илэрхий мэдрэгдэж байна.

Ач буяны түмэн гайхамшигийг өөртөө агуулж цогцлоосон эхийн дүрийг бүтээхдээ ангир шар уургийн ач тусаар эсээгээ эхэлсэн нь ч оносон гэлтэй. Эхийн сүү шиг амьд гал уураг, ид шидэт рашаан энэ ертөнцөд өөр үгүй юм. "Эхийн сүү" хэмээх хэсэгт тоолбол нас чацуу, төөлбөл бие чацуу Энх, Мөнх

гэдэг хоёр баатар эрийн тухай өгүүлнэ. Сарангоо гэдэг үзэсгэлэнт бүсгүйд тэр хоёр баатар сэтгэл алдарчээ. "Аавын хоёр хүү, адилхан хоёр баатрыг алаглаж үзээд яах вэ. Эрийн гурван наадам хийгээд хэн дийлсэн нь намайг ав" хэмээн Сарангоо хэлж байна. Бүсгүйн нүдэнд Мөнх нь илүү жавхлантай харагдаж сэтгэлийг нь татаж байвчиг Сарангоо дээрх хариуг хэлэхдээ "Мөнх дийлбэл миний аз, Энх дийлбэл түүний аз" хэмээн дотроо бодож байна.

Эхлээд морь уралдуулахад Энхийн хилэн хар морь Мөнхийн үүлэн бор морийг өдөржийн газар орхин түрүүлж иржээ. Дараа нь сур харвахад Энхийн тавьсан сум гурван өртөөний чанад дахь байнаас сөөм дутаж харин Мөнхийн тавьсан сум байгаа яг оножээ. Залгуулаад барилдаан эхэлж байна. Хоёр баатар ургахын улаан нарнаас шингэ-хийн шар наран хүртэл ана мана, ач тач барилдаж Энх нь эрмэг сайхан тонгорох гэтэл Мөнх өргөөд тавьчихаж гэнэ хэмээн эсээнд өгүүлжээ.

Баатар эр Мөнх Сарангоо бүс-гүйтэй хувь заяагаа нэгтгэн найр хурим хийж байна. Мөнхийн баруун талд Энх найз нь сууж, Сарангоогийн зүүн биед урт цагаан сахалтай, хурц гярхай нүдэт ухаант мэргэн өвгөн тухалжээ. Найр наадам ид жигдрэх үед мэргэн өвгөн хоёр баатарт хандаж:

— Мөнх, Энх хоёр маань ихэр юм шиг ижилхэн сайхан эрс юм. Өвгөн миний шинжсэнээр бол Мөнх хүү ачит эхийнхээ сүүг цадтал хөхөж өссөн юм байна. Энх хүү буянт малын сүүгээр хүн болсон байна. Үзээд өгье гэсэн ч өөр ялгаа алгаа гэжээ. Энх баатар ам нээж:

— Өвгөн буурал ах минь үнэнийг та айлдав. Нарангэрэлт ээж минь намайг төрүүлээд зул мэт жаргасан гэдээг хэмээн хариулжээ. Зохиогч Энх баатрын энэхүү хариулт дээр *"Ачит эхийн сүүний гайхамшиг ийм ажгуу"* гэсэн зургаан үгтэй ганцхан өгүүлбэр шигтгэн төгсгөжээ.

Эхийн ангир шар уургийн ид шидийг үүнээс илүүтэйгээр, үүнээс илүү үнэмшилтэйгээр илэрхийлэн гаргана гэдэг үнэндээ бэрх юм. Ачлалт эх хүний аугаа гайхамшигт нэг чанар нь чухам үүнд оршдог ажээ.

"Эх" эсээний дараах хэсэг нь "Эхийн бүүвэй" гэсэн гарчигтай. Энд зохиогч өмнөхийн нэгэн адил домог ахуй, зан үйлийн зохиомжийг дүрслэл болгож ашиглажээ. Эрт урьдын цагт ах дүү хоёр баатар охин дүүгийн хамт аж төрдөг байж. Охин дүү нэгэн хөөрхөн хүү төрүүлсэн нь жирийн адуучин эрийн үр удам байжээ. Үүнийг олж мэдмэгц нэг ах нь "Миний дүүгийн нөхөр хүлэг сайн баатар байх ёстой" хэмээн уурсан хилэгнэжээ. Нөгөө ах нь охин дүүгээ өмөөрч "Адуучин хүн хэрийн баатраас дутуугүй эрэлхэг, хийморьтой эр байдаг юм. Түүнийг урьж цөмөөр эв найртай аж төрсүгэй" хэмээжээ. Ийнхүү хоёр ахын үзэл бодол зөрөлдөж эвдрэлцсэн байна. Үгээ эс ололцвол зэвсгээр ярьдаг ёсон тэр цагт ноёрхож байсан тул охин дүү нь хоёр ахыгаа хэрхэн яаж эвлэрүүлэх вэ хэмээн шаналж бодолхийлсээр нэгэн мэргэн ухаан сийлж өлгийтэй хүүгээ зориуд уйлуулаад уянгалуулан бүүвэйлжээ. Алаг нүдэндээ нулимс мэлмэрүүлэн, мэлтэлзүүлэн бүүвэйлжээ. "Нар тононд байхаас авахуулаад ханын

элгэнд очтол бүүвэйн дуу аялж гэнэ. Хоёр ах нь үг сөрөхөө болиод бодол болон сууцгаажээ. Сууж сууж том ахынх нь нүднээ шүүдрийн дусал мэт нулимс гялалзав гэнэ. Бага ах нь гүн ихээр санаа алдав гэнэ. Хоёулаа босоод тэврэлдэв гэнэ. Охин дүүгээ зээтэйгээ хамт тэврэв гэнэ” хэмээн зохиогч нүдэнд харагдаж, сэтгэлд ургатал дүрслэн үзүүлсэн байна.

Дашдоржийн Нацагдоржийн “Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн ижий” хэмээх эрдэнийн содон мөр энд үлгэр домгийн өнгөөр хувилан та бидний өмнө амилан босч ирж байна. Эх хүний бүүвэйн дуу гэдэг энэ ертөнцийн түм буман дуу авиан дундаас хамгийн эгшиглэнт хосгүй хүчтэй нь лав мөн биз ээ. Таван тивийн бүх эхийн бүүвэйн дуу бүхнийг уяруулан хайлуулах ер бусын ид шидтэй гэдэгт хэн эргэлзэх билээ. Зохиогч “Эх” эсээнийхээ “Эхийн бүүвэй” хэсгийг “Эхийн эгшиглэнт бүүвэйд энхэр нялхсыг байтугай эрэлхэг баатрыг номхруулан уяраах ийм их ид шид бий билээ” хэмээн төгсгөөд “Эхийн хайр” хэмээх дараах хэсгээр залгуулан үргэлжлүүлжээ. Энэ удаад үлгэр домгийг бус, өөрт тохилдсон бодит жишээг ашигласан байна.

Бажуудайн Ганбат бол Говь-Алтай аймгийн Тонхил сумын уугуул. Цаст Богд Сутай хайрханы суганд, тунгалаг уст Зүйл голын хөвөөнд түүний жаргалант бага нас өнгөрчээ. Энэ тухайгаа тэрбээр “Мөнх цаст Сутай хайрханаас эх авсан жигтэйхэн тунгалаг устай Зүйл голынхоо хөвөөнөө хорь гаруйхан настай хонгор сайхан ээж минь юм угааж, би зайдуюхан тоглож байлаа. Гэнэт ээж минь машид

сандран миний зүг гүйхээрээ ирлээ. Юу болсныг эс ойлгосон би дэмий л эхийн өөдөөс гайхан харав. Ээжийн нүд дүгрэглэн соньхон янз ороод царай нь цайчихсан байх шиг. Ээж минь дээрээс халхлан тэвэрч авлаа. Зүрх нь луг лугхийн мэдэгдэм хурдан цохилж, цоройн тус газар нь түргэн түргэн оволзон амьсгаална” хэмээн дүрслэн үзүүлсэн байна. Үүнийгээ уншигчдад “Ээж минь амжиж над дээр ирээгүйсэн бол дээр нь эргэлдэгч элээний сүүдэр хүүг нь дайрах байж л дээ. Хүүхдийг элээний шүүдэр дайрвал гай болдог гэсэн тэр цагийн ойлголт байжээ. Ээж минь үүнд итгэж явсан хэрэг” хэмээн тайлбарлажээ. “Эхийн хайр гэдэг мөн ч аугаа юм даа” гэж уг хэсгийг часхийтэл зангидаж төгсгөсөн байна. Өөрт нь тохиолдсон үнэн бодит зүйл учраас уншигчдад бүр ч илүү үнэмшилтэй сонсогдож байна.

Хүн бүр эхдээ туйлаас хайртай. Зохиолчид, сэтгүүлчид ч мөн тэдний нэгэн адил, тэгэхдээ бусдаас ялгарах нэг онцлог бий. Үнэн хайраа үгээр сийлж, дүр дүрслэлээр амилуулан тэмдэглэж үлдээх нь тун элбэг. Нийтлэлч Бажуудайн Ганбат энэ үүргээ гялалзтал сайхан биелүүлсэн байна.

Энэ мэтээр зохиогч “Эх” хэмээх тэр аугаа их ертөнцийг тал бүрээс нь гүйцэд нээн үзүүлэх гэж хичээнгүйлэн байж өөрийн эсээгээ алхам алхмаар ургуулан сийлбэрлэж урлажээ. “Эхийн ач” хэсэгт эх хүн үрийнхээ төлөө үхлээс ч үл айн тахал өвчин туссан хүүгээ сүүлчийн амьсгалаа хураатал нь асран тойлсоор өөрөө хамтдаа зул мэт хайлан жаргаж

буйгаар дүрсэлсэн бол “Эхийн зориг” хэмээх нөгөө хэсэгт жараад оны сүүлчээр Алтай нутагт болж өнгөрсөн үнэн бодит жишээгээр иш татаж эх хүн үрийнхээ төлөө галзуу чонын аманд ч ганцаараа орохоос буцдаггүйг үнэмшилтэйгээр харуулсан байх жишээтэй ажээ.

Эх хүн үрдээ ангир шар уургаа шимүүлэн хөхүүлж, үүрийн гэгээнээс үдшийн бүрий хүртэл үрийн бүүвэй аялж, бусдаас хамгаалж өмгөөлж энэрэн хайрлаж өсгөхдөө үг яриа, үйл хөдлөл нэг бүрээрээ амьдрах эрдэмд сургаж, хорвоотой танилцуулдгийг “Эхийн эрдэм” хэсэгтээ өгүүлсэн бол үрээ гэсэн эхийн сэтгэл ямар аугааг “Эхийн сэтгэл” хэсэгт зохиогч зураг адил зурж үзүүлсэн байна. Эх хүн аугаа их зөн совинтой болохыг “Эхийн совин” хэсэгт өгүүлсэн нь маш үнэмшилтэй болсныг зориуд тэмдэглэе. Хот газарт сургуульд сурч буй хүүгээ хөвөнтэй цамцтай, үс нь ургачихсан, царай муутай явж байна гэж хар даран зүүдлээд хэрдхийн сэргэж байгаа эх хүн уншигч бидний нүдэнд харагдах шиг л болж байна. Өвгөнөө хөөж туух нь холгүйд хүрч хот руу явуулж байна. “Гэтэл хүү нь залуустай дарвин зодоон хийсэн хэргийн учир байцаагдаж байжээ. Хэрэг түвэг тарьсан өдөр хоног нь эхийнх нь зүүдэлж, совин татсан тэр үетэй дүйж байв гэнэ” хэмээн зохиогч эсээндээ өгүүлжээ. Иймэрхүү тохиолдол амьдралд цөөнгүй тохиолддог. Лавтай учрыг шинжлэх ухаан тайлах биз ээ хэмээн цохож тэмдэглэсэн байна.

“Эхийн нүд” хэмээх хэсэгт зохиогч долоо наймтай балчирхан бага насандаа шувууны үүрэн дэх гурван өрвөгөр ангаахайг харж амаа ангалзуулан хоол

нэхэх тэдгээр нялх амьтдыг өрөвдөхдөө тогооны өрөм авчирч өгөхөөр гэртээ очоод ээждээ зэмлүүлсэн тухай өгүүлж байна. Энэ тухай тэрбээр “Ээжийн царай хувьсхийснээ “Ээ бурхан минь! Шувууны үүрэнд хүний сүүдэр тусах төдийд л ээж нь ангаахайнуудаа голчихдог юм. Хоол ч өгөхгүй, эргэж тойрох ч үгүй бүрмөсөн хаячихдаг юм. Чамайг би орхиод бүр явчихвал чи яах вэ?” гээд л зэмлэж гарлаа. “Чамайг би орхиод бүр явчихвал чи яах вэ?” гэсэн үг надад айхтар туслаа” гэжээ. Энэ хэсэг хөдөө нутагт төрж, өссөн бидний үеийнхэнд маш ойлгомжтой, бүр сэтгэл зүрхэнд ойр дотнохон бууж байна. Нүүдэлчин омгийн монголчуудын аж төрөх ёсонд нэвт шингэсэн гүн ухааны нэг тод илэрхийлэл. Товч тодорхой, маш оновчтой дүрслэл болсон гэж үнэлмээр байна.

Үйлдэлдээ үнэхээр гэмшсэн, ангаахайнуудыг өрөвдөж нүд дүүрэн нулимс цийлэгнүүлсэн жаал хүүгийн нүдэнд ээжийнх нь нүүр царай хилэнтэй мэт, үг сургамж нь зэмлэж байвч харин нүд нь энхрийлж байх мэт харагдахад л сая сэтгэлийн дотор зул асаж тайтгарсан тухай өгүүлжээ.

Эхийн нүдэнд ийм нууцхан увидас, үрээ гэсэн гүн их хайр багтаж байдгийг алдрай багахан насандаа олж мэдэрсэн зохиогч эх хүн цагаа болохоор цаглашгүй их сүртэй хэмээн баталжээ. Эхийн энэ сүрийг уран зохиолын дээж бичгээс эрж хайж түүж авсан байна. “Монголын нууц товчоо”-ноос иш татаж Чингис хаан дүү Хасарын ханцуйг уяж малгай, бүсийг нь аваад байцаан асууж байхад нь сүйх тэргэнд цагаан тэмээ хөллөөд шөнөжин явж наран ургахтай зэрэгцэн хүрч ирсэн

Өэлүн эхээ үзээд эзэн Чингис хаан эмээн зайлав. "Эхийн сүр хааныг хүртэл эмээлгэж байжээ. Эх хүн ус мөрөн лүгээ ижил уяхан дөлгөөн ч цаг ирж, хэрэг тохиовол уулс мэт сүртэй юм" хэмээн дүрсэлсэн байна.

Бажуудайн Ганбатын энэхүү тансаг ховорхон шигтгээг уншаад алс холын Дагестан нутгийн суут хөвгүүн Расул Гамзатовын нэгэн шүлэг санаанд гялсхийн бууж билээ. Уулын хүмүүс омголон дошгин, халуун цустай тул өчүүхэн зүйлээс ч үг сөргөлцөж үсрэн босоод мэс хангинуулан зөрүүлж цус урсгах нь нэг бус удаа бий. Тийм эгзэгтэй хурц мөчид эх хүн босон харайж толгойн алчуурыг авч тэмцэлдэгчдийн зүг шидэх юм бол ямар ихээр уурлан дайсагналцсан байлаа ч уулын барс шиг дошгин эрс үг дуугүй захирагдаж, хэрүүл тэмцлээ нэн даруй зогсоодог ховорхон сайхан заншил миний ард түмэнд бий хэмээн тэр шүлэгт бичсэн байж билээ. Үүнээс үзэхэд газар газрын хүн ардын дунд эх хүнийг эрхэмлэн дээдэлж, үг сургаалыг нь ёсчилон дагаж ирсэн сайхан уламжлал түгээмэл байдаг байж болох юм.

Ингэн хавтгайн сүүгээр цай сүлж уулгасан биш

Ээжийнхээ ачийг би юугаар хариулсан гэх вэ дээ!

Эмийн цэцэгсийн шүүдрээр дарс нэрж дайлсан биш

Эх, үрсийн өрийг би юугаар төлсөн гэх вэ дээ! гэсэн сэтгэлийн яруухан дуучих Явуухулангийн шүлгийн мөрөөр Бажуудайн Ганбат "Эх" эсээгээ төгсгөөд "Хүн гэгч эхийнхээ далай ачийг хариулж яахан чадах вэ, яахан барах вэ!" хэмээн

нэмж тодотгожээ. Эхийнхээ тухай үгээр чадал заан урлаж босгосон гэрэлт хөшөө мөн байна гэж үнэлэхийг хүсч байна. Утга агуулга төгс төгөлдөр, үг өгүүлбэрүүд нь монгол сэтгэхүйгээр нэн зохистойгоор нийтгэгдэн томогдож зохиомжлогдсон хөгжимлөг сайхан хөрөг. Ийм уянгалаг эсээ Монголын сэтгүүл зүйд тийм ч олон бишээ.

"Эх" эсээ бол Монголын уншигчдын сэтгэлд нийцэж, сэтгүүлчдийн сэтгэлийг хөдөлгөж гижигдсэн сайн бүтээл болсон юм. Цөөнгүй оюутан "Эх" эсээгээр курс, дипломын ажил хамгаалсан байдаг. Сэтгүүл зүй, утга зохиолын шүүмжлэгч, судлаачдын нүдэнд өртсөн нь ч нэг биш. Зохиогчтой хамт "Үнэн" сонинд ажиллаж байсан Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, ахмад сэтгүүлч Хорлоогийн Цэвлээ энэ бүтээлийг гоц гойдоор сонирхон ишлэл татаж дурдаад "Бажуудайн Ганбат агсны дотоод сэтгэлийн ертөнцийг энэ эссе ямар нэг хэмжээгээр зураглаж байгаа гэдэгт итгэж байна. Чигч, туйлбартай, хатуу шаардлагатай, заримдаа гашуун үгтэй харагддаг боловч цаанаа бол их зөөлөн талдаа, сэтгэлийн хөдөлгөөн ихтэй, өрөвч, уяхан, бас инээд муутай, хөөрхөн шогч нэгэн байсан юм. Чухам л гадаад тал нь Халхын сайхан Юндэн гөөгөө, дотоод санаа нь олон нялх хүүхэдтэй монгол эх хүн шиг тийм л бялхмал эр байсан гэж би хувьдаа дүгнэж явдаг"¹ хэмээн дурссан бол утга зохиолын судлагч шүүмжлэгч Д.Өлзийбаяр "Манай Б.Ганбат чинь бас сайн өгүүллэгч. Түүний олон чамбай өгүүллэгийг энд цөмийг дурдах шаардлагагүй ч "Эцэг", "Эх" гэсэн уянгалаг, сэтгэл хөдлөм хоёр эссе-

өгүүллэгийг онцлох учиртай. Хар багадаа өнчирсөн болоод ч тэр үү, уншихад самсаа шархирч байснаа би одоо ч мартаагүй байна² хэмээн өндрөөр үнэлжээ.

Нэр бүхий дээрх хүмүүсийн хэлж тэмдэглэснээс хоёр зүйл миний анхаарлыг гойд татсан болно. Х.Цэвлээ гуай “Эх” эсээг зохиогчийн өөрийнх нь дотоод сэтгэлийн ертөнцтэй холбож, түүнийг олон нялх хүүхэдтэй монгол эх хүн шиг тийм бялхмал эр байсан гэж би хувьдаа дүгнэж явдаг гэсэн нь маш сонин эргэцүүлэл мөн. Үнэхээр тийм байсан байж ч болох юм. Тийм ч учраас “Эх” хэмээх эл тансаг эсээг чухамхүү зураглаж хөрөглөж бүтээсэн байж мэднэ. Утга зохиолын судлагч, шүүмжлэгч Д.Өлзийбаяр “Эцэг”, “Эх” хэмээх бүтээлүүдийг уянгалаг, сэтгэл хөдлөм эссе-өгүүллэг хэмээн нэрлэжээ. Өөрөөр хэлбэл Бажуудайн Ганбатын нийтлэлийн хоёр бүтээлийг уран зохиолын өгүүллэгийн түвшинд аваачин тавьж үнэлсэн байна. Хүмүүс, тэр тусмаа утга зохиолын мэргэжлийн шүүмжлэгч хүн Бажуудайн Ганбатын сэтгүүл зүйн бүтээлүүдийг утга зохиолын зиндаанд жишээлэн нэрлэж байгаа бол энэ нь яавч муу үзүүлэлт огт биш.

Одоо зохиогчийн “Эцэг” хэмээх өөр нэг эсээг товч авч үзье. Энэ бол “Эх” эсээний үргэлжлэл гэж хэлж болно. Бажуудайн Ганбат “Эцэг” эсээгээ “Засгийн газрын мэдээ” сонины 1996 оны 4-р сарын 25-ны өдрийн №76 (516)-д нийтлүүлжээ. Өөрөөр хэлбэл “Эх” эсээгээ бичсэнээс хойш найман жилийн дараа туурвин хэвлүүлсэн байна. Удтал бодож боловсруулсан байж таарна.

Ижил төстэй зүйлийг хүмүүс нэг медалийн хоёр тал гэж хэлж зүйрлэдэг шиг эх, эцэг гэсэн ойлголт ер нь өргөн утгаараа бараг адил агуулгатай юм. Тэр үүднээс зохиогч бүтээлдээ хандсан болов уу гэж би хувьдаа таамаглаж байна. Үүнийг ч “ЗГМ” сонины газраас “Эцэг” эсээний магнайд ямар нэг байдлаар тодотгожээ. Тэнд “Тэрбээр “Эх” эсээнийхээ хэлбэрээр “Эцэг” хэмээх эсээ бичсэнээ бидэнд өгснийг уншигч Танаа толилуулж байна” гэсэн байна. “Ааваа гэж дуудахуй ам дүүрэн, Аавыгаа харахуй нүд дүүрэн” гэж зохиогч “Эцэг” эсээнийхээ өмнөтгөлд хоёр мөр шүлгийн шигтгээс хатгаад “Тэнгэр эцэг, газар эх мину” хэмээн монгол хүн сүслэн залбирдаг ажаам. Эцэг болбоос тэнгэр язгууртай” хэмээн эсээгээ эхэлжээ. “Эх” эсээнийхээ нэгэн адилаар “Эцэг” эсээг “Эцгийн сүр”, “Эцгийн нэр”, “Эцгийн хайр”, “Эцгийн түшиг”, “Эцгийн ухаан”, “Эцгийн сэтгэл” хэмээсэн зургаан хэсэг гарчигт багцлан хураангуйлж зураглан хөрөглөсөн байна.

“Бибээр Алтай нутгийн хүү билээ. Тэнгэр, газрын хооронд ихэмсэглэн сүглийж, мөнгөлөг цагаан оргил нь нэгэнтээ үүлэн дундаа умбан далд орж, нөгөөтэй гялбалзанхан ил гарах сүрлэг их Сутай хайрханаа харахуй өөр юутай ч бус гагцхүү аавтайгаа зүйрлэмээр санагддаг юм. Харах бүрий нүд дүүрэн хан буурал аавыгаа үзэхүй Сутай хайрхантайгаа зүйрлэмээр бодогддог юм. Ийнхүү уулаа харахаар аав шиг минь, аавыгаа харахлаар уул шиг минь үзэгддэг билээ... Ай Сутай хайрхантайгаа адил, мөнх тэнгэр шигээ сүр хүчтэй ачтай эцэг Таньдаа мөргөө, хүү чинь”

хэмээн “Эцгийн сүр” хэсэгтээ аавынхаа тухай аялгуу тансгаар зураглан сэтгэл зүрхнийхээ хайрыг илэрхийлсэн байна. Монгол хүн бүрийн сэтгэлд хүрч шингэхүйц Алтай нутгийн хүүгийн үнэн зүрхний өчил гэлтэй.

“Сайн үйл бүтээсэн хүний тухай монголчууд ярилцахдаа “Эцгийнхээ нэрийг мандууллаа даа!” гэгцээдэг. Өөрийнхөө нэрийг мандууллаа гэдэггүй. Муу үйл хийсэн хүний тухайд “Эцгийнхээ нэрийг хөөдлөө дөө” хэмээн харуусдаг” гэсэн энгүүн атлаа туйлын ойлгомжтой, туйлаас үнэмшилтэй өгүүлбэрээр “Эцгийн нэр” хэсэг нь эхлээд “Хэний хэн бэ гэхэд миний нүүр улайдаггүй. Сайн эцгийн нэр хир халдаашгүй ариун шүтээн, эрдэнэ мэт үнэтэй өв хөрөнгө мөнөөс мөн. Ай эцэг Таныхаа бүтэн нэрд сөгдөн мөргөө, хүү чинь” хэмээн төгсгөжээ.

Эцэг хүний хайр гаднаа биш дотроо байдаг тухай, эмнэг даагыг өөрөө чихдэн тогтоож байгаад хүүгээ мордуулж эр хүн шиг эр хүн болгодог хал нь гаднаа хайр нь дотроо аавынхаа тухай “Эцгийн хайр” хэсэгтээ товойлгон гаргасан бол эцгийн түшиг уул мэт нөмөртэй, ухаан туршлага нь далай мэт яндашгүй болохыг “Эцгийн түшиг” хэмээх гарчгийн дор тодорхой өгүүлжээ. Үүнийгээ улам улам лавшруулж эцгийн ухаан холч байдаг, аавын бийд хүнтэй танилц, агтны бийд газар үз

гэж сургадгийг сургуулиа төгсөөд говь нутагт ажиллахаар явсан өөрийн жишээгээр иш татаж хүүрнэсэн байна. Зохиогч “Эцэг” хэмээх эсээгээ “Эцгийн сэтгэл” гарчгаар зангидаж төгсгөсөн нь бас учиртай аж. “Эцгийн сэтгэл эхийнхээс өөрцгүй. Би хувьдаа үүнийг өрх тусгаар болсон тэр цагаасаа мэдэх болсон юм. Үзэгдээгүй хэд хоночихоод яваад очиход аавын нүд гэрэл татан

баярлаж байж билээ. Хүн баярлахаараа нүд нь гэрэлтдэг гэдгийг би тэгэхэд л анзаарсан ...Эцэг хүний сэтгэл эхийнхээс ялгаагүй уян зөөлөн, хайлган цайлган” хэмээн өгүүлсэн байна. Тэнд бас аав, ээж гэдэг хоёр сайхан эрдэнээ харж түмэн хайр, буман энхрийлэлд умбана гэдэг тавь шахсан насанд олдошгүй жаргал болох тухай өгүүлж

«

*Эцэг хүний хайр гаднаа биш
дотроо байдаг тухай, эмнэг
даагыг өөрөө чихдэн тогтоож
байгаад хүүгээ мордуулж эр хүн
шиг эр хүн болгодог хал нь гаднаа
хайр нь дотроо аавынхаа тухай
“Эцгийн хайр” хэсэгтээ товойлгон
гаргасан бол эцгийн түшиг уул
мэт нөмөртэй, ухаан туршлага нь
далай мэт яндашгүй болохыг
“Эцгийн түшиг” хэмээх гарчгийн
дор тодорхой өгүүлжээ.*

»

байна. Ингэж эх, эцэг гэдэг хоёр нэгдмэл нэг цогцос, нийлмэл хосгүй ховорхон эрдэнэ юм гэсэн санааг илэрхийлэн гаргажээ. Зохиогчийн энэхүү туйл тайлал нь “Эцэг” хэмээх эсээ нь “Эх” эсээгийн шууд үргэлжлэл мөн гэсэн миний санааг улам бататган баталж байгаа болно. Эцэст нь ганц жижигхэн баримтыг нэмж хэлье. Зохиогч хорин жилийн өмнө бичсэн “Эх” эсээнийхээ төгсгөлд *Б.Ганбат* гэж бичсэн бол найман жилийн дараа туурвисан “Эцэг” хэмээх эсээнийхээ ард *Бажуудай*

Ганбат хэмээн тодотгон онцгойлсон байна. Энэ ч гэсэн түүний торгон мэдрэмжийн нэг тод илрэл мөн гэлтэй. Бажуудайн Ганбат энэ үед зөвхөн эх, эцэг хоёрын хөвгүүн төдийгүй, Эх орны нэрд гарсан том уран бүтээлч болоод байсан юм. Сэтгүүлч Бажуудайн Ганбат "Эх" ба "Эцэг" хэмээх хосолмол эсээ туурвиж төрүүлсэн эх, эцэг хоёртоо ийнхүү үгийн гэрэлт хөшөө босгожээ. Үүгээрээ өөрийгөө уран үгсийн дадлагажиж туршлагажсан мастер гэдгээ батлан харуулж, энэ нь ч Монголын сэтгүүл зүйд дахин давтагдашгүй үнэт бүтээл болж чадсан байна.

Монгол Улсын нэрд гарсан авьяаслаг сэтгүүлч Бажуудайн Ганбатын зарим нийтлэлийн уран чадварын талаар товч хөндөж ярихад ийм байна. Гэвч энэ бол хангалтгүй юм. Хөгжимлөг нийтлэлч Б.Ганбатын хүнлэг сайхан чанарын талаар цөөн боловч үгийг нэмж хэлэхгүйгээр түүний бүтээл туурвилын агуулгыг бүрэн гүйцэд ойлгох аргагүй билээ. Тэр бол үнэхээрийн ховор сайхан хүн байв. Ахмад сэтгүүлч Хорлоогийн Цэвэлээ гуайн нэгэнтээ Халхын сайхан Юндэн гөөгөө дүрээрээ мөн байна гэж тодорхойлсон Бажуудайн Ганбатыг Монгол Улсын Ардын уран зохиолч, яруу найрагч Дөнгөтийн Цоодол "Дулаахан бор царай, сэргэлэн алаг нүд, эрэгтэй хүнд гоёдсон гэмээр үл ялиг ээтгэр шулуун хамар, нургилсан сайхан дуу, долгиолсон хар үс нь одоо ч санаанд тодхон байна"³ хэмээн "Лоо" уулсын шинжээчийн тухай бичиглэхийн учир" дурсамждаа нүдэнд харагдтал тодоор нэхэн дүрсэлсэн бол түүнтэй олон жил

"Үнэн" сонинд хамт ажилласан ахмад туршлагатай сэтгүүлч Гэндэнгийн Бямбажал "Ясны зарчимч хүн" дурсамждаа "Алдаа мадагт өртөхгүйн тулд манайхны зарим нь бичсэн зүйлээ Ганбаа руу барьж гүйдэг байсан юм шүү... Залуугаасаа зарчимтай явж ирсэн Ганбаа маань суга дэвшин "Үнэн" сониныхоо хариуцлагатай нарийн бичгийн дарга болов. Армиар бол жанжин штабын дарга гэсэн үг. Ёстой тэр их айлыг командалсан шиг командалж байсан"⁴ гэжээ.

"Үнэн" сонинд нэг насаараа ажилласан ахмад сэтгүүлч Д.Дорждулам гуай "Мартахын аргагүй хүн" дурсамждаа "Ганбаа угийн хашир, няхуур нямбай, аливаад хувийн болон ажлын дээд зэргийн зохион байгуулалттай хүн учраас ажилдаа жинхэнэ эзэн болж чаддаг байлаа. ...Наяад оны дунд үе хүртэл Монголын ямар ч сонин сэтгүүл, радио, телевиз хөндөж байгаагүй нийгмийн эмзэг, тэр үедээ хориотой байсан сэдвүүд болон төв, орон нутгийн нам, төрийн удирдлагын хүнд суртал, хөшүүн хойрго ажиллагааг "Үнэн" сонин зоригтой шүүмжилж, нийгмийн тогтолцоог өөрчлөхийг ил цагаан шаардсан нийтлэлийг бараг дугаар алгасахгүй гаргаж уншигчдын чихийг соотойлгож байгаа. Үнэн хэрэг дээрээ бол бид ардчиллыг эхлүүлсэн хэмээн эдүгээ цээжээ дэлдэж буй залуусыг "өлгийдөө" нойрсож байхад Л.Түдэв, Б.Ганбат нарын тэргүүлсэн "Үнэн" сонин ардчиллын салхийг жинхэнэ ёсоор хагалж "Салхич шувууны дуу"-г хадааж байсан юм.

Ерөнхий эрхлэгчийн заавар зөвлөгөө, хамт олныхоо хүчин чармайлтад түшиглэсэн Ганбаа маань уг ажлыг гардан

зохион байгуулж тэр үедээ л “Үнэн” сонинд Ганбатын “школ”-ыг бий болгосон хүн шүү дээ. Энэ үеэс “Үнэн” сонины нийтлэлийн бодлого эрс шинэчлэгдэж, нүүр царай нь өөрчлөгдөн, захиалагчдын тоо ч нэмэгдсэнийг тэр үеийнхэн мартаагүй бизээ”⁵ хэмээн хөдөлбөргүй үнэнийг баримт түшиж өгүүлэн бичсэн байна.

Түүний энэхүү үнэлгээг Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, манай нэртэй нийтлэлч, шүүмжлэгч С.Лочин улам тодотгож “Үнэн” сонины нийтлэлийн бодлогын өөрчлөлт “тухайн үедээ цоо шинэ үзэгдэл байсан бөгөөд Монголын өөр ямар ч хэвлэл ийм алхам хийгээгүй байв. Ийм өөрчлөлтийг ерөнхий эрхлэгч Л.Түдэв, хариуцлагатай нарийн бичгийн дарга Б.Ганбат нар гардан зохион байгуулж хийсэн гэдгийг өнөөдөр шударгаар хэлэх цаг болсон байхаа!”⁶ хэмээн өөрийн “Бат журамт залуу анд Бажуудайн Ганбат минь” дурсамждаа чанга дуугаар зарлан мэдэгджээ. Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч С.Жамбалдорж “Говиос тодорсон нэрт сэтгүүлч” гарчигтай дурсамждаа Б.Ганбат бол “Хүнлэг сэтгэлтэй, холч сэтгэлгээтэй хүн”⁷ хэмээн тодорхойлсон байдаг. Түүнийг төрүүлж өсгөсөн, эдүгээ наян насыг зооглоод байгаа элбэрэлт эх Ч.Цэрэнпил гуай “Бурхан болохоосоо 3-4 хоногийн өмнөхөн ээждээ гадаа салхинд гарахдаа дороо тавьж сууж бай гээд сандлын зөөлөвч авчирч өгснийг одоо хүртэл дороо тавьж хайртай хүүгийнхээ тухай олон олон дурсамжийг санагалзан эрхээ эргүүлэн залбирч суудаг даа, би...”⁸ гэсэн нь сэтгэл шимшрүүлэх шиг л болж байна. Бажуудайн Ганбатын

хүнлэг, зарчимч, шударга, зүтгэлтэй, хөдөлмөрч шинж чанарыг тодруулж товойлгон тэмдэглэсэн ийм жишээ баримт олныг дурдаж болно.

Тэгэхийг энэ удаад түр түдгэлзээд гагцхүү дээр дурдсан ишлэлүүд дээ үндэслэж өөрийн үнэлэлт дүгнэлтийг хийх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Энэ нь: **Нэгдүгээрт**, “Үнэн” сонины газарт хянагч, утга зохиолын ажилтан, утга зохиолын нарийн бичгийн дарга, хариуцлагатай нарийн бичгийн даргаар тасралтгүй 18 жилийн турш ажилласан авьяаслаг сэтгүүлч, нийтлэлч Бажуудайн Ганбат өөрийн бүхий л авьяас чадвар, хүч хөдөлмөрийг энэ сонины нийтлэлийг чанаржуулан сайжруулж баялаг утга агуулгатай болгохын төлөө бүрэн зориулж, Ганбатын хэмээх сэтгүүл зүйн хэвшил дадал буюу “Үнэн” сонины өвөрмөц сургуулийг (“школ”) бий болгосон байна гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна. **Хоёрдугаарт**, энэхүү Ганбатын хэмээх хэвшил дадал, “Үнэн” сонины өвөрмөц содон сургууль бүрэлдэн төлөвших оргил үе нь цаг хугацааны хувьд өнгөрсөн зууны наяд оны сүүлч ерээд онтой давхацжээ.

Ингэснээр “Үнэн” сонин Монголд ардчилсан чөлөөт хэвлэл бүрэлдэн төлөвших эхлэлийг тавьж, түүний цаашдын хөгжилд хүчтэй нөлөө үзүүлсэн байна. Энэ утгаар нь Лодонгийн Түдэв, Бажуудайн Ганбат нарын зэрэг сэтгүүлчдийг Монголд чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх үйлсэд мэдэгдэхүйц хувь нэмрээ оруулж гавьяа байгуулсан нэрт нийтлэлчид, чадамгай зохион байгуулагчид мөн гэж үзэж болохоор байгаа юм.

“Эх”, “Эцэг” зэрэг торгомсог, уянгалаг, хөгжимлөг олон сайхан нийтлэлээрээ Монголын сэтгүүл зүйн түүхэнд мөнхөрч, өөрийн гэсэн өвөрмөц тод мөрийг үлдээсэн, тус улсад чөлөөт ардчилсан хэвлэлийг үүсгэн хөгжүүлэх үйлсэд гар бие оролцож, зам харгуйг нь засалцсан сэтгүүлч Ганбат бол зөвхөн Бажуудай аавын сайн хүү, Цэрэнпил ээжийн хайртай хөвгүүн төдийгүй, Монгол Улсын нэрд гарсан нийтлэлч, үзэг нэгт сэтгүүлч нөхдийнхөө хайр хүндэтгэлийг хүлээсэн, өнөөдөр ч тэднийхээ сэтгэл зүрхэнд нь уятай хэвээр байгаа түшигт сайн нөхөр, алдрай багын минь анд минь билээ гэсэн үгээр энэхүү шүүмжээ би өндөрлөж байна.

Ишлэл

¹ 2007. Уул шиг түшигтэй нөхөр минь. УБ., 63 дахь тал.

- ² Мөн тэнд, 44-45 дахь тал.
- ³ Мөн тэнд, 13 дахь тал.
- ⁴ Мөн тэнд, 58 дахь тал.
- ⁵ Мөн тэнд, 74-75 дахь тал.
- ⁶ Мөн тэнд, 81 дэх тал.
- ⁷ Мөн тэнд, 101 дэх тал.
- ⁸ Мөн тэнд, 153 дахь тал.

Резюме

Рецензия посвящена творчеству известного монгольского журналиста, писателя Бажуудайн Ганбата. Б.Ганбат, окончивший Государственный Педагогический институт Монголии, а также Институт литературы им. А.М. Горького, являлся одной из наиболее культовых фигур монгольской журналистики 1980-1990-хх гг. Автор в качестве образца подверг анализу его эссе “Мать” и “Отец”, которые по-праву считаются эталоном данного жанра.